



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ



**ГЭР БҮЛИЙН
ХҮЧИРХИЙЛЭЛ ХҮҮХДЭД
ҮЗҮҮЛЭХ ҮР ДАГАВАР**

www.ub-subcenter.mn

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ҮР ДАГАВАР



Хүчирхийлэлтэй гэр бүлд хүүхэд, ээж эсвэл аавыгаа доромжлуулж, зодуулж шаналан зовж байхыг **ХАРДАГ**. Тэд заналхийлэл, сүрдүүлэлт, зодоон цохионы дуу чимээг **СОНСДОГ**.

Хүчирхийллийн ул мөр болох цус, нулимс, хөхөрч няцарсан шарх, хагарсан, урагдсан, эвдэрсэн эд юмсыг **АЖИГЛАЖ МЭДЭРДЭГ**.

Хүүхэд гэр бүлдээ хүчирхийллийн “хуримтлал, бухимдал, тэсрэлт” хэрхэн өрнөж байгааг **МЭДДЭГ**.



ХҮҮХДЭД ЯМАР ТОХИОЛДОЛД ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ ВЭ ?

Энэ асуултын хариуг хүмүүс сайн мэддэг. Хүүхдэд хамгийн чухал нь аюулгүй найдвартай, хүчирхийлэлгүй гэр бүл, түүнийг анхаарч, сонсож, халамжилж, хайрлаж, урам өгдөг эцэг эх юм.

ХҮҮХДЭД ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПИРАМИД

ХАМГААЛАХ


Аюулгүй байдлыг нь хангах

ХАМГААЛАХ БА НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Гэр бүлийг дэмжих, аюулгүйн төлөвлөгөө

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хүчирхийллийн дарамтнаас хамагаалах, эрт илрүүлэх, гэр бүлийг дэмжих



ХҮҮХДЭД ЯАРАЛТАЙ ХАМГААЛАЛ ҮЗҮҮЛЭХ 8 ТОХИОЛДОЛ



1. Бэртэл гэмтэл авсан
2. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй сэжиг таамаг илэрсэн
3. 0-6 насны хүүхдүүд асран хамгаалагчгүй орхигдсон
4. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асран хамгаалагчгүй орхигдсон
5. Онцгой байдал, орчны аюул, эрсдэлтэй нөхцөлд хүүхэд байгаа
6. Эцэг эх нь архидан, мансуурсны улмаас асран халамжлах чадвараа алдсан
7. Хүүхэд хүчирхийлэл, айлган сүрдүүлэлтэн дор болон хорионд нийгмээс тусгаарлагдсан
8. Хүүхэд барьцаалагдсан нөхцөлд байгаа

ХҮҮХДЭД ЗАЙЛШГҮЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ

8 ТОХИОЛДОЛ



- 1 Гэр бүлийн таагүй орчноос дайжиж айлаар, гадуур хоноглож буй
- 2 Сургууль завсардсан, завсардах эрсдэлтэй, хичээл таслах, хоцрогдолтой, тэвчишгүй хөдөлмөр эрхэлдэг
- 3 Бүлэг хамт олондоо дасах зохицох чадвар сул, эсвэл гадуурхагддаг
- 4 Амжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдралтай, өөрийн гэсэн гэр оронгүй
- 5 Зан үйлийн эрсдэлтэй, гадуур тэнэх, хулгай, дээрэм хийх..., гэх мэт гэмт хэрэгт холбогдсон, хохирогч, гэрч, байцаан шийтгэх ажиллагаанд хамрагдаж байгаа, ял хойшлогдсон, тэнсэн харгалзах ял эдэлж байгаа, сургалт хүмүүжлийн албадлагын арга хэмжээ авагдсан
- 6 Өөрийгөө гэмтээх болон, амиа хорлох үйлдэл хийж байсан, хийх эрсдэлтэй
- 7 Эцэг эх нь архины хамааралтай, хүчирхийллийн харилцаатай орчинд өсөж торниж буй
 - Эцэг эх, асран хамгаалагчид өөрчлөлт орсон хүүхэд
 - Бүтэн өнчин боловч асран хамгаалах эцэг эх нь албан ёсоор тогтоогдоогүй
 - Эцэг эх, асран хамгаалагчаа алдсаны (сүүлийн 1-2 жил) улмаас уй гашууд автсан
 - Эцэг эх нь салалтын үеийн хямралд байгаа
 - Дахин гэрлэлт, шинэ эцэг эхдээ дасан зохицох хямралтай байгаа хүүхэд
 - Айлд байгаа “тавиул” эсвэл үрчлэгдсэн хүүхэд
 - Эцэг эх нь тусдаа амьдардаг хүүхэд
 - Дотуур байр, асрамж халамж, хамгаалах байр, хорих ангид байрлаж буй хүүхэд
 - Өрх толгойлсон хүүхдүүд

Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдэд үзүүлэх үр дагавар

0-2 НАСАНД

Энэ насанд хүүхэд хүрээлэн байгаа орчинтой танилцах идэвхтэй үйлдэл хийж эхэлдэг. Дуртай, дургүй зүйлсээ үгээр болон биеийн хөдөлгөөнөөр илэрхийлнэ. Хоёр наснаасаа хүүхэд хэрүүл зодооноос зугатах, нуугдах, ээжийгээ уйлахад нь аргадах, айх, гомдох зэрэг зан үйлдэл гаргадаг. Хүүхэд бага насных байх тусам илүү хохирол хүлээдэг.

2-8 НАСАНД

- Энэ насанд хүүхэд “би” төвтэй байдаг. Хүүхэд эргэн тойронд болж байгаа юмс үзэгдлийн шалтгааныг зөвхөн тухайн зүйлстэй холбож, зөв бурууг үл ялгана. Хүчирхийлэл дарамт ч гэсэн өөрсдөөс нь болдог гэж ойлгодог. Би “ ээжийгээ уурлуулчихлаа” гэж боддог. Тэд хүчирхийллээс зугтаж, нуугдаж, бусдаас тусламж, хамгаалал хүлээдэг.
- Хүчирхийллийн харилцаатай гэр бүлийн бага насны хүүхдэд илрэх шинж тэмдэг: айдас түгшүүртэй, цочимтгой, хөмсгөө зангидсан, биеэ барьсан, уйтгар гунигтай, хэт бишүүрхүү, танихгүй хүн хараад айж нүүрээ буруулан уйлах, юмны доогуур, ард орж нуугдах, удтал уйлж тайвшрахгүй байх, ганцаараа байхаас маш их айх, хар дарж зүүдлэх, шөнө байн байн сэрж уйлах, орондоо шээх, хуруугаа хөхөх, бусад хүүхдүүдтэй харилцаж тоглохдоо тэднийг зодох, хазах, үснээс нь зулгаах зэрэг хүүхдэд баймааргүй хүч хэрэглэсэн үйлдэл гаргах, хүчирхийлэгчийн үйлдлийг дуурайж үзүүлэх, өвчлөмтгий байх зэрэг шинж тэмдгүүд илэрдэг.

8-12 НАСАНД

- Энэ насанд хүүхэд хүчирхийлэл дарамтыг зогсоохыг чармайдаг. Эцэг эх нь зодолдсон, хэрүүл шуугиантай байх нь түүний буруу мэт санагддаг, ичдэг. Гэвч яаж ч оролдоод юуг ч өөрчилж чадахгүйдээ ЦӨХӨРЧ тусламжгүйдэж бухимддаг. Хүүхэд энэ насандаа хамт олны дунд орж, хүлцэнгүй номой эсвэл түрэмгийлэх байдлаар өөрийгөө хэт хамгаалсан харилцаанд ордог. Эцэг эхтэйгээ харилцахаас зайлсхийж, дургүйцдэг. Тэдэнд итгэх итгэл алдагдаж хүндлэхээ болих хандлага төлөвшдөг.
- Тэд айдас түгшүүрээр дүүрэн байдаг, дараагийн хүчирхийлэл хэзээ, хэрхэн үйлдэгдэхээс байнга түгшин санаа нь зовиноно. Хүчирхийллийн шалтаг шалтгаан нь юу байх бол гэдгийг мэдэх

боломжгүй байдаг нь тэдэнд “аюулгүй” гэсэн мэдрэмжийг өгдөггүй. Тиймээс байнга өөрийнхөө, гэр бүлийнхнийхээ төлөө санаа нь зовж түгшиж шаналж байдаг.

- Эцэг эхчүүд хэрүүл маргаандаа “энэ хүүхэд байгаагүй бол чамаас салчихсан, хүүхдээ бодсондоо ингэж шаналж байна” гэхчлэн ярьдаг нь хүүхдэд хандаагүй ч түүнийг буруутан гэсэн мэдрэмжийг өгдөг байна. Энэ байдлаас үүдэн “надаас л болж хэрүүл тэмцэлтэй амьдардаг юм байна” гэсэн ойлголттой болж өөрийгөө хэнд ч хэрэггүй, юу ч хийж чадахгүй гэсэн бодол тээж зарим нь эцэг эхээсээ хөндийрч гэрээсээ дайжих, хичээл тасалж тэнэх хандлагатай болдог байна.
- Тэд насанд хүрсэн ч алив дарамт хүчирхийллийн хохирогч болох эрсдэл эсвэл хүчирхийлэгч болох магадлал өндөр байдаг. Учир нь амьдралд нь тохиолдох дарамт хүчирхийлэлд тэд хохирогчийн үүднээс хариу үзүүлэх хандлагатай байдаг. Жишээлбэл тэдэнд асуудлыг хүчирхийллийн бус замаар шийдэх мэдлэг, үлгэр дуурайлал, туршлага байдаггүй бөгөөд дарамт хүчирхийллийн нөхцөл байдаг үүсмэгц шууд айж түгшдэг, өөрийгөө буруутгадаг, хүчирхийлэгчийг дуугүй тэвчих, аргадаж царайчлах зэргээр хүүхэд байхдаа харж, сонсож, мэдэрч байсан хохирогчийн хариу үйлдлийг давтан хийдэг.

12-ООС ДЭЭШ НАСАНД

- Өсвөр насныхан нь хүчирхийлэл бол тэдний эцэг, эхийн асуудал гэж үздэг. Хүчирхийлэл хохирол, түгшүүр авчирдаг. Хүчирхийллийг зогсоож чадахгүй байгаад зарим үед ээждээ уурладаг. Аав нь ээжийг нь зодох, доромжлоход айж жигшдэг, гомддог, уур уцаартай, баяр баясгалангүй, ганцаардсан, өөрийгөө буруутгасан, өөрийн үнэлэмж, амьдралын итгэл үнэмшил эргэлзээтэй бүрхэг болдог. Эдгээр мэдрэмжүүд нь ихэвчлэн уураар илрэн гардаг. Энэ насанд хэрэв аав нь хүчирхийлэл үйлддэг бол эрэгтэй хүн гэр бүлдээ ноёлдог, эмэгтэй хүн эрхшээлд нь байдаг гэдэгт итгэн үнэмшиж, дасаж эхэлдэг.
- Хүчирхийлэл, дарамттай гэр бүлийн хүүхэд “нууцыг хадгалах ёстой” гэсэн ойлголттой байдаг бөгөөд тэд энэ талаар хэнд ч ярьдаггүйгээс гадна өөр хоорондоо ч айдас, зовиур, өвдөлтөө ярьж хуваалцдаггүй байна. Тиймээс ч гаднаас нь харахад асуудалгүй мэт боловч сэтгэлийн гүнд гүн гүнзгий зовнил, шархыг чимээгүйгээр тээж явдаг. Тэд ичгүүр, уур хилэн, доромжлол, басамжлалыг байнга мэдэрч эцэг эхийн анхаарал халамж, хайр энхрийлэл, сайшаал магтаалаар өлсөж цангасан байдаг байна.



Тэдний оюуны, бие баялдрын мөн хүмүүжлийн өсөлт, хөгжил эрсдэл, хүндрэлүүд бодитоор нүүрлэж байдаг.

- Дарамт, хүчирхийлэлтэй гэр бүлийн бага насны хүүхэд гол төлөв сэтгэл зүйн хямралд өртсөн байдаг нь тэдний оюуны хөгжилд, тухайлбал, сэтгэн бодох болон мэдрэхүйн хөгжилд нь муугаар нөлөөлж байдаг.
- Тэд хэл ярианы бэрхшээлтэй болох, анхаарлаа төвлөрүүлэх чадвар нь сул байх, шинэ зүйлийг ойлгож сурахдаа удаан зэрэг асуудалтай байдаг. Өсөж том болоход нь эдгээр шинж тэмдгүүд үргэлжлэхийн зэрэгцээ илүү хүнд асуудлууд нүүрлэж байдаг.
- Бага ангидаа унших, ойлгох, ярих чадвар нь үеийн хүүхдүүдтэй харьцуулахад сул байх жишээтэй. Дунд, ахлах ангидаа сэтгэл зүйн дарамт, хямрал нь гүнзгийрсээр сэтгэл гутралд орж өөрийгөө өвтгөх, амиа хорлох оролдлого хийх, мансуурах, донтох зэрэг аюул нүүрлэж байдаг.
- Түүнчлэн “хүлээн зөвшөөрч болох, болохгүй үйлдэл” –ийн талаар төөрөгдөлд орсон байдаг нь эцэг, эх нь бие биенээ үг хэлээр дайрч доромжилж, улмаар нэг нь нөгөөгөө зодож гэмтээдэг ч эргээд бие биедээ хайртай, дуртай мэт болсон байдаг нь хүүхдийн хувьд ойлгомжгүй өөрийн ухаандаа тайлбарлахад төвөгтэй харилцаа байгаад зогсохгүй дотнын хүндээ ингэж хандаж бас гар хүрч болдог юм байна гэсэн ойлголтыг өгдөг байна.

ХААНА ХАНДАЖ МЭДЭЭЛЭХ ВЭ?



107

Гэр бүлийн хүчирхийллийн
дуудлага хүлээн авах,
зөвлөгөө, мэдээлэл өгөх утас



102


Цагдаагийн мэдээлэл,
шуурхай удирдлагын төв



108

Хүүхдийн тусламжийн утас

БАЙНГА...24 ЦАГААР АЖИЛЛАНА /нэгж шаардахгүй/



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага
тойруу 1, Амарын гудамж-2, Соёлын төв өргөө, Г-корпус-415

Утас: (976)-70003099

Факс: (976)-70003098

И-мэйл: info@ub-subcenter.mn

Веб: www.ub-subcenter.mn